

“ГЕРМЕС ЦЕНТР” ХК-ИЙН 2025 ОНЫ
ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ
ХУРЛЫН МАТЕРИАЛ

УЛААНБААТАР ХОТ

1. Хувьцаа эзэмшигчдийн хурлын зар
2. Хурлаар хэлэлцэх асуудал
3. Хувьцаа эзэмшигчдийн хурлын дэг
4. Компанийн 2025 оны үйл ажиллагааны тайлан
5. Компанийн 2025 оны санхүүгийн тайлан
6. Компанийн 2025 оны санхүүгийн аудитлагдсан тайлангийн тухай
7. Компанийн засаглалын бүтэц, үйл ажиллагаа
 - Хувьцаа эзэмшигчдийн бүтэц
 - Нөлөө бүхий хувьцаа эзэмшигчдийн талаарх мэдээлэл
 - Компанийн нэгдмэл сонирхолтой этгээд тэдгээрийн эзэмшилд буй хувьцааны талаарх мэдээлэл
 - Төлөөлөн удирдах зөвлөлийн бүрэлдэхүүн
 - ТУЗ-ийн үйл ажиллагааны тайлан болон ТУЗ-ийн дэргэдэх хороодын үйл ажиллагааны тайлан
8. Хөрөнгийн зах зээл ба компанийн хувьцааны үнэ ханш
9. Компанийн ногдол ашиг хуваарилалт
10. Компанийн 2025 оны үйл ажиллагааны болон санхүүгийн аудитлагдсан тайлангийн тухай
11. Компанийн 2025 оны үйл ажиллагааны болон санхүүгийн аудитлагдсан тайланд Төлөөлөн удирдах Зөвлөлөөс гаргасан дүгнэлтийг хэлэлцэн батлах тухай
12. “Компанийн дүрэм”д өөрчлөлт оруулах тухай
13. Компанийн ТУЗ-ийн гишүүдийг шинэчлэн сонгох тухай
14. Компанийн 2026 оны үйл ажиллагааны зорилтыг танилцуулах
15. Компанийн 2026 оны ТУЗ-ийн төсвийг батлах тухай
16. Хурлаас гарах тогтоолын төсөл

“ГЕРМЕС ЦЕНТР” ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ЗАР

“Гермес центр” ХК-ийн ТУЗ-ийн 2026 оны 2-р сарын 11-ний өдрийн №4 тоот тогтоолоор Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг 2026 оны 04-р сарын 10-ны өдрийн 15:00 цагт тус компанийн оффисын байрны 3 давхарт байрлах танхимд зохион байгуулахаар болсон тул Эрхэм хүндэт хувьцаа эзэмшигчид та бүхнийг хуралдаа идэвхитэй оролцохыг урьж байна.

Хуралд оролцох эрхтэй хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалт гаргах бүртгэлийн өдрийг **2026 оны 03-р сарын 09-ний** өдрөөр тасалбар болгоно.

Хурлаар хэлэлцэх асуудал :

- ✓ Компанийн 2025 оны үйл ажиллагааны болон санхүүгийн аудитлагдсан тайлангийн тухай
- ✓ Компанийн 2025 оны үйл ажиллагааны болон санхүүгийн аудитлагдсан тайланд ТУЗ-өөс гаргасан дүгнэлтийг батлах тухай
- ✓ “Компанийн дүрэм”-д өөрчлөлт оруулж батлах тухай
- ✓ Компанийн ТУЗ-ийн гишүүдийг шинэчлэн сонгох тухай
- ✓ Компанийн 2026 оны үйл ажиллагааны зорилтын тухай
- ✓ Компанийн 2026 оны ТУЗ-ийн төсвийг батлах тухай

Эрхэм хувьцаа эзэмшигч та бүхэн хурлын материалтай өөрийн харьяалагдах брокер, дилерийн компани болон Улаанбаатар хот, Баянгол дүүргийн 25-р хороо, Нарны зам-20, “Гермес центр”ХК-ийн төв оффисын байрны 3 давхар № 302 тоот өрөөнд ажлын өдрүүдэд утсаар холбогдон 10:00-17:00 цагийн хооронд хүрэлцэн ирж танилцана уу.

Хурал зохион байгуулах:

Комиссын дарга: О.Энхтуяа, утас 9909-4991, имэйл хаяг: enkhee_7777@yahoo.com
Гишүүн : Д.Эрдэнэсүрэн, утас 9908-8571, имэйл хаяг: erdenesuren2213@gmail.com

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛААР ХЭЛЭЛЦЭХ АСУУДАЛ

1. Компанийн 2025 оны үйл ажиллагааны болон санхүүгийн аудитлагдсан тайлангийн тухай
2. Компанийн 2025 оны үйл ажиллагааны болон санхүүгийн аудитлагдсан тайланд Төлөөлөн удирдах Зөвлөлөөс гаргасан дүгнэлтийг хэлэлцэн батлах тухай
3. “Компанийн дүрэм”-д өөрчлөлт оруулах тухай
4. Компанийн ТУЗ-ийн гишүүдийг шинэчлэн сонгох тухай
5. Компанийн 2026 оны үйл ажиллагааны зорилтыг танилцуулах
6. Компанийн 2026 оны ТУЗ-ийн төсвийг батлах тухай

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ДЭГ

№	Хэлэлцэх асуудал	Хугацаа	Хэлэлцүүлэгч	Хурлын шийдвэр
1	Хувьцаа эзэмшигчид хурлын танхимд цуглах	5 минут	Хурал зохион байгуулах комисс	Хурлын тэмдэглэлд оруулах
2	Хурлын тэргүүлэгчийг сонгосон тухай	5 минут	Хурлын дарга Д.Оюунсүрэн	Хурлын тэмдэглэлд оруулах
3	Хурлын тооллогын комиссын дүнг танилцуулах	5 минут	Тооллогын комисс	Тогтоолоор батлах
4	Компанийн 2025 оны үйл ажиллагааны болон санхүүгийн аудитлагдсан тайлангийн тухай	10 минут	Гүйцэтгэх захирал Б.Оюунцэцэг	Хурлын тэмдэглэлд оруулах
	Санал шүүмжлэл	5 минут	Хувьцаа эзэмшигчид	
5	Компанийн 2025 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайланд ТУЗ-өөс өгсөн дүгнэлт	10 минут	Аудитын хорооны дарга Д.Туяа	Тогтоолоор батлах
	Санал шүүмжлэл	10 минут	Хувьцаа эзэмшигчид	
6	“Компанийн дүрэм”-д өөрчлөлт оруулж батлах тухай	5 минут	Хурлын дарга Д.Оюунсүрэн	
	Санал шүүмжлэл	5 минут	Хувьцаа эзэмшигчид	
7	Компанийн ТУЗ-ийн гишүүдийг шинэчлэн сонгох тухай	10 минут	Хурлын дарга Д.Оюунсүрэн	
	Санал шүүмжлэл	5 минут	Хувьцаа эзэмшигчид	
8	Компанийн 2026 оны үйл ажиллагааны зорилтын тухай		Гүйцэтгэх захирал Б.Оюунцэцэг	Хурлын тэмдэглэлд оруулах
	Санал шүүмжлэл	10 минут	Хувьцаа эзэмшигчид	
9	Компанийн 2026 оны ТУЗ-ийн төсвийг батлах тухай		Хурлын дарга Д.Оюунсүрэн	Тогтоолоор батлах
	Санал шүүмжлэл	10 минут	Хувьцаа эзэмшигчид	

КОМПАНИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

Манай компани нь өнгөрсөн 2025 онд 16 ажилтан, ажиллагсадтайгаар үйл ажиллагаагаа явуулж, батлагдсан орлого, зарлагын төсөв төлөвлөгөөний дагуу дараах ажлуудыг хийж гүйцэтгэлээ. Үүнд:

1. Хүний нөөцийн талаар:

- Компанийн ажилтан ажиллагсадтай 2025 оны гэрээг шинэчлэн байгуулж, ажиллагсдын ажлыг “Ажилтны үнэлгээний хуудас”-аас улирал тутамд дүгнэж байна.
- Ажиллагсдын ээлжийн амралтыг батлагдсан хуваарийн дагуу амраасан. Мөн сар бүр ажилтан ажиллагсдын ажил, амралтын хуваарийг баталж, өдөр тутмын үйл ажиллагаанд хяналт тавин ажиллаж байна.
- Компанийн нягтлан бодогч, мэргэжилтэн нар нь өөрсдийн хариуцсан ажилтан ажиллагсад өдөр бүр ажил хэргийн мэдээ, мэдээллийг өгч, харилцан зөвшилцөх зарчмаар хамтран ажиллаж байна. Мөн гүйцэтгэх захирал сар бүр ажиллагсдын хурлыг тогтмол хийж, шаардлагатай мэдээллийг өгч байна.
- Батлагдсан ажлын төлөвлөгөөний дагуу хуваарьт ажлуудыг өдөр тутамдаа хийж гүйцэтгэж байна.

2. Түрээслэгчдийн талаар:

- Гүйцэтгэх удирдлагын баг нь худалдааны төвийн түрээслэгчидтэй байгуулсан 2025 оны түрээсийн гэрээний гүйцэтгэлийн явцын үнэлгээг түрээслэгч тус бүртэй хамтран дүгнэж, улмаар 2026 оны 1-р сарын түрээсийн төлбөрт
 - ✓ 150 түрээслэгчид 91-ээс дээш оноо авч 10%-ийн хөнгөлөлтийг
 - ✓ 55 түрээслэгчид 71-90 хүртэлх оноо авч 5%-ийн хөнгөлөлтийг эдэлсэн болно.
- “Реха мед” эмнэлэгтэй хамтран түрээслэгчид болон ажиллагсад зориулсан эрүүл мэндийн өдөрлөгийг 2025 оны 11-р сарын 27-ны өдөр зохион байгуулсан. Тус эмнэлгийн зүгээс эмэгтэйчүүдийн эмчийн зөвлөгөө, хөхний мэс заслын эмчийн үзлэг, зөвлөгөө, сэргээн засах эмчийн зөвлөгөө, зөв хооллолтын талаарх зөвлөгөө, сахар, цусны даралтын үзлэг, оношлогоо зэргийг үнэ төлбөргүй үзүүллээ.
- “Монгол даатгал” ХХК-тай хамтран даатгалын ач холбогдол, даатгалын төрөл зүйл, даатгалын хамрах хүрээ болон даатгуулагчид учирсан аливаа хохирлыг хэрхэн барагдуулах талаарх мэдээ мэдээллийг танилцуулсан.
- “Худалдаа хөгжлийн банк”, “Голомт банк”, “Төрийн банк”, “Капитрон банк”-тай хамтран түрээслэгчдэд зориулсан санхүүгийн өдөрлөгүүдийг зохион байгуулсан.
- Худалдааны төвийн түрээслэгчид, тэдгээрийн худалдагч туслах ажилтнуудад болон иргэдэд зориулан хэрэглээний халуун хүйтэн ус, тог цахилгааныг зөв зохистой ашиглах, хэмнэх талаарх таниулга сурталчилгааг тогтмол хийж байна.
- Худалдааны төвийн түрээслэгчдэд сар бүр тогтмол захидал хүргүүлж байна. Мөн түрээслэгчдээс ирсэн санал, хүсэлт, гомдлыг тухай бүр харилцан зөвшилцөх зарчмаар хамтран ажиллаж байна.

3. Галын аюулгүй байдлын талаар:

- Онцгой байдлын газраас өгсөн шаардлагын хүрээнд компанийн “Гамшгийн эрсдэлийн нарийвчилсан үнэлгээ”-г худалдааны төвийн түрээслэгч “Евро ази сервис” ХХК-иар хийж гүйцэтгүүллээ. Энэхүү үнэлгээнд гамшиг болох гал, газар хөдлөлт, үерийн үед учирч болох аливаа эрсдэлийг бууруулахад компанийн удирдлагын зүгээс ямар арга хэмжээг, хэрхэн авч ажиллах талаарх заавар

зөвлөмжийг ирүүлсэн. Эдгээр заавар зөвлөмжийг өдөр тутмын үйл ажиллагаандаа хэрэгжүүлж чадсан тохиолдолд аливаа гамшиг ослыг эрсдэл багатай даван туулах боломжтой юм.

- Худалдааны төвийн түрээслэгч, тэдгээрийн худалдагч, туслах ажилтнуудад галын аюултай нөхцөл байдлаас хэрхэн урьдчилан сэргийлж ажиллах талаарх зөвлөгөө, мэдээллийг сар бүрийн захидлаар дамжуулан хүргүүлээ.

4. Харуул хамгаалалтын талаар:

- Худалдааны төвийн зохицуулагч нарт хулгай, залилан, дээрэм тонуулаас урьдчилан сэргийлж ажиллах талаар зөвлөгөөг тогтмол өгч байна.
- Худалдааны төвийн гадна, дотор талын хяналтын камерын хэвийн үйл ажиллагааг хангаж, тусгайлсан дэвтэрт тэмдэглэгээ хийж, эвдэрч гэмтсэн тохиолдолд тухай бүр засварлаж ажилласан.

5. Аж ахуйн засварын талаар:

- Батлагдсан төсвийн хүрээнд худалдааны төвийг цахилгааны эх үүсвэрээр хангадаг байсан 10 000 квт-ын хос шугамыг шинэчилж солих ажлыг “Бадамлах хүч” ХХК-тай гэрээ байгуулан хийж гүйцэтгүүлээ. Ингэснээр цахилгааны найдвартай эх үүсвэртэй болж улмаар худалдааны төвийг хэвийн ажиллах боломжийг бүрдүүлсэн.
- Худалдааны төвийн цэвэр, бохир усны тоолуурын баталгаат хугацаа дууссаныг шинэчлэн баталгаажууллаа.

6. Цэвэрлэгээ, үйлчилгээний талаар:

- Худалдааны төвийн гадна болон дотор талд өдөр тутмын цэвэрлэгээ үйлчилгээг тогтмол хийж, түрээслэгч, худалдан авагчдад цэвэр цэмцгэр, ая тухтай орчныг бүрдүүлэн ажиллаж байна.
- Худалдааны төвийн хог хаягдлыг 7 хоног бүр ачуулж, улмаар гадна талбайд байрлах хогийн функерийг ариутган цэвэрлэж байна.
- “Хог хаягдлын тухай хууль”-ийн 10.2.10 дахь заалтын дагуу худалдааны төвийн эргэн тойрон дахь нийтийн эдэлбэр газрын хог хаягдал, цас мөсийг тухай бүр цэвэрлэж байна.
- Нийслэл болон БГДүүргээс зохион байгуулж байгаа олон нийтийг хамарсан цэвэрлэгээ үйлчилгээнд ажиллагсдаа тогтмол оролцуулж, худалдааны төвийн ойр орчмын 50м хүртэлх нийтийн эдэлбэр газрыг байнга цэвэрлэж, оршин байгаа дүүрэг хорооныхоо өнгө үзэмжинд өөрсдийн хувь нэмрээ оруулж ажиллав.

7. Архив бичиг хэргийн талаар:

- Өмнөх оны санхүүгийн болон үйл ажиллагаатай холбоотой баримтууд, түрээсийн гэрээ, ТУЗ, ХЭХуралтай холбоотой баримт материалуудыг үдэж, архивласан.
- Түрээслэгч иргэн, аж ахуйн нэгжийн хүсэлтийн дагуу түрээсийн тодорхойлолт, түрээс төлөлтийн тайлан зэрэг мэдээ мэдээллийг гарган өгч байна.
- СЗХ, МХБирж болон бусад харилцагч байгууллагуудаас ирүүлсэн албан тоотуудыг бүртгэлжүүлж, холбогдох хариуг боловсруулан хүргүүлж байна.

8. Олон нийттэй харилцах талаар:

- Компанийн www.hermescenter.mn, МХБ-ийн www.mse.mn цахим хуудсан дахь ТУЗ, ХЭХ болон компанийн санхүү, үйл ажиллагаатай холбоотой мэдээллүүдийг тогтмол шинэчилж байна.
- Худалдааны төвийн түрээслэгчдэд сар бүрийн захидлаар дамжуулан тухайн сард хийгдсэн ажил үйлчилгээ, дараагийн сарын ажил амралтын өдөр, ажиллах цагийн хуваарь, худалдааны төвийн дотоод журам зэргийн талаарх мэдээ мэдээллийг тогтмол хүргүүлж байна.

КОМПАНИЙН САНХҮҮГИЙН ТАЙЛАН

- Компанийн мөнгөн урсгалын тооцоог урьдчилан гаргаж, мөнгөн хөрөнгийн зохицуулалтыг тогтмол хийж, орлого, зарлагын төсвийн гүйцэтгэлд өдөр тутам хяналт тавин ажиллалаа.
- Санхүүгийн тайлан мэдээллийг тогтоосон хугацаанд гаргаж, холбогдох зохицуулагч байгууллагуудад тайлагнаж байна.
- Улсад төлөх ёстой татвар хураамж, ашиглалтын болон бусад зардлуудыг цаг тухайд нь бүрэн төлж байна.
- Худалдааны төвийн түрээслэгчдээс авах түрээсийн орлогыг тухайн сардаа багтааж бүрэн хураан авч, түрээсийн төлбөрийн үлдэгдэлгүй ажиллаж байна.
- Ажиллагсдын ээлжийн амралтын нөхөн олговор, ХЧГА-ны тэтгэмж зэргийг цаг тухайд нь холбогдох хууль, журмын хүрээнд тооцон олгож байна.
- Компанийн 2025 оны санхүүгийн тайланд “Си Эс Ай” ХХК-тай байгуулсан гэрээний дагуу 2 удаагийн хөндлөнгийн аудитын ажлыг хийлгэсэн. Хурлын материалын 9-13-р хуудаст аудитын компанийн дүгнэлт хавсаргагдсан болно.

1. Компанийн санхүүгийн үндсэн үзүүлэлтийн тухай :

- Компанийн нийт хөрөнгө 9,119.0 сая ₮ бөгөөд үүнээс:
 - ✓ Эргэлтийн хөрөнгө 3,530.1 сая ₮
 - ✓ Үндсэн хөрөнгө 3,300.4 сая ₮
 - ✓ Биет бус хөрөнгө 2,288.5 сая ₮
- Эзэмшигчийн өмч хөрөнгө 8,694.7 сая ₮
- Татварын дараах цэвэр ашиг 2,073.5 сая ₮ байна.

2. Орлогын үр дүнгийн тухай : Компани 2025 онд 3,096.2 сая төгрөгийн борлуулалтын орлоготой ажиллалаа. Борлуулалтын орлогын төлөвлөгөө 3,059.9 сая төгрөг байсантай харьцуулахад 101%-ийн биелэлттэй гарч, төлөвлөгөөг 36,3 сая төгрөгөөр давуулан биелүүлсэн. Хадгаламжийн хүүний орлогын төлөвлөгөө 500,0 сая төгрөг байсан бол гүйцэтгэл 523,0 сая төгрөг болж төлөвлөгөөг 23,0 сая төгрөгөөр давуулан биелүүлж ажиллалаа. Компанийн 2025 оны нийт орлогын төлөвлөгөө 3,559.9 сая төгрөг байхаас гүйцэтгэлээр 3,616.2 сая төгрөг болж төлөвлөгөөг 59,3 сая төгрөгөөр давуулан биелүүлж ажиллав.


3. Зардлын тухай: Компани 2025 онд 1,315.3 сая төгрөгийн зардалтай ажилласан. Зардлын төлөвлөгөө 1,427.5 сая төгрөг байсантай харьцуулахад 92%-ийн биелэлттэй гарч төлөвлөгөөг 112,2 сая төгрөгөөр хэмнэн ажиллалаа.

4. Ашгийн тухай: Татварын дараах цэвэр ашиг 2,073.5 сая төгрөг гарсан. 2025 оны ашгийн төлөвлөгөө 1,919.1 сая төгрөг байсантай харьцуулахад 108%-ийн биелэлттэй гарч төлөвлөгөөг 154,4 сая төгрөгөөр давуулан биелүүллээ.

5. Ногдол ашгийн тухай: 2025 онд нэгж хувьцаанд оногдох ногдол ашгийн хэмжээ 26 төгрөг 40 мөнгө гарсан. Нэгж хувьцаанд ногдох ногдол ашгийн төлөвлөгөө 24 төг 43 мөнгө байсантай харьцуулахад 108%-ийн биелэлттэй гарч, төлөвлөгөөг 1 төг 97 мөнгөөр давуулан биелүүлж ажилласан.

Компанийн сүүлийн 5 жилийн санхүүгийн үзүүлэлтүүдийг дараах графикуудаар харуулав.

График 1




КОМПАНИЙН ТӨСӨВТ ТӨВЛӨРҮҮЛСЭН ТАТВАР, ШИМТГЭЛ

6. Төсөвт төвлөрүүлсэн татвар, шимтгэлийн тухай: Манай компани нь 2025 онд нийт 848,4 сая ₮-ийн татварыг улсад төлсөн байна. Үүнд:

- ААН-ийн ОАТатварт 219,2 сая ₮
- НДШимтгэлд 113,6 сая ₮
- ХХОАТатварт 57,0 сая ₮
- НӨАТатварт 272,2 сая ₮
- ҮХЭХАТатварт 56,6 сая ₮
- Ногдол ашгийн татварт 118,0 сая ₮
- Газрын төлбөрт 11,8 сая ₮

Сүүлийн 5 жилийн хугацаанд Монгол Улсын татварын албанд төлсөн татварын хэмжээг харуулав.

График 2





“СИ ЭС АЙ АУДИТ” ХХК

БҮРТГЭЛ ХЯНАЛТЫН ИТГЭМЖЛЭГДСЭН БАЙГУУЛЛАГА

Монгол улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг

4 дүгээр хороо, Цэцээ гүн төвийн 207 тоот

Утас: (976) 70001981; (976) 99096584;

И-мэйл: csi_sevjee@yahoo.com

2026.01.29 № 25/01

танай _____ -ны № _____ -т

ХАРААТ БУС АУДИТОРЫН ТАЙЛАН

Зөрчилгүй дүгнэлт

Бид 2025 оны 12 дугаар сарын 31-ээрх санхүүгийн байдлын тайлан, жилийн эцсээрх орлогын дэлгэрэнгүй тайлан, өмчийн өөрчлөлтийн тайлан, мөнгөн гүйлгээний тайлан, нягтлан бодох бүртгэлийн гол бодлогууд, тодруулгаас бүрдсэн “Гермес центр” ХК-ийн санхүүгийн тайланд аудит хийж гүйцэтгэлээ.

Бидний үзэж байгаагаар эдгээр санхүүгийн тайлангууд нь бүхий л материаллаг асуудлаар “Гермес центр” ХК-ийн 2025 оны 12 дугаар сарын 31-ээрх санхүүгийн байдал, тухайн жилийн санхүүгийн гүйцэтгэл болон мөнгөн гүйлгээг Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандартууд, Монгол улсад мөрдөгдөж байгаа хууль дүрэм журмын дагуу үнэн зөв толилуулсан байна.

Зөрчилгүй дүгнэлтийн үндэслэл

Бид энэхүү аудитын ажлыг Аудитын Олон Улсын Стандартуудын дагуу хийж гүйцэтгэв. Уг стандартуудын дагуу хүлээсэн үүрэг хариуцлагаа энэ тайлангийнхаа санхүүгийн тайлангийн аудитад хүлээх аудиторын үүрэг хариуцлага хэсэгт харуулав. Бид санхүүгийн тайлангийн энэхүү аудитын ажилд Мэргэжлийн нягтлан бодогчдын ёс зүйн дүрэм болон Монгол улсын мэргэшсэн нягтлан бодогчдын ёс зүйн дүрмийн дагуу үүрэг хариуцлагаа бүрэн биелүүлсэн. Олж авсан аудитын баримт нотолгоо нь бидний гаргасан дүгнэлтийн үндэслэл болоход хангалттай, тохиромжтой гэж итгэж байна.

Аудитын гол асуудлууд

Бидний мэргэжлийн шийдлийн үнэлэмжээр, сонгон авсан горимуудад алдаа болон залилангийн улмаас санхүүгийн тайлан буруу илэрхийлэгдэх эрсдэлийн үнэлгээг багтаан санхүүгийн тайланд аудитын ажлыг гүйцэтгэхэд аудитад хамгийн ихээр нөлөө үзүүлэхүйц асуудлууд нь аудитын гол асуудлууд болдог. Аудитын явцад санхүүгийн тайланг бүхэлд нь хамруулан авч үзсэн бөгөөд аудитын агуулгын хүрээнд дүгнэлт гаргахад нөлөөлсөн ба асуудлуудын улмаас дүгнэлтээ хязгаарлаагүй.

Аудитын гол асуудлууд нь тайлант жилийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн ач холбогдолтой байсан гэж аудиторын мэргэжлийн үнэлэмжээр үзсэн асуудлууд юм. Эдгээр асуудлуудыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь анхаарч, аудиторын дүгнэлт өгөхдөө авч үзсэн бөгөөд бид уг асуудлуудын талаар тусдаа дүгнэлт гаргадаггүй болно.

Бидний мэргэжлийн үнэлэмжээр олж авсан аудитын нотолгоо дээрээ тулгуурлан тухайн байгууллагын тасралтгүй байх чадавхын талаар ноцтой эргэлзээ төрүүлэхүйц үйл явдал, нөхцөл байдал ажиглагдаагүй тул аудитын гол асуудал байхгүй гэж үзэж байна.

Бусад мэдээлэл

Санхүүгийн тайлангуудад өгсөн бидний дүгнэлт нь бусад мэдээлэлд хамаарахгүй бөгөөд тэдгээрт аливаа хэлбэрийн баталгаажуулах дүгнэлт гаргаагүй болно. Хэрэв бид аудитын тайлангийн өдрөөс өмнө олж авсан бусад мэдээлэлд хийсэн өөрсдийн ажилд үндэслэн бусад мэдээлэл нь материаллаг буруу илэрхийлэл агуулсан байна гэж дүгнэвэл энэ тухайгаа тайлагнах шаардлагатай. Үүний дагуу тайлагнах зүйл бидэнд байхгүй болно.

Компанийн үүрэг хариуцлага

Удирдлага нь санхүүгийн тайлагналын олон улсын стандартуудын дагуу эдгээр санхүүгийн тайлангуудыг бэлтгэх, үнэн зөв толилуулах хариуцлага хүлээх бөгөөд мөн залилан эсвэл алдаанаас үүдэх материаллаг алдаатай тайлагналгүй санхүүгийн тайлангуудыг бэлтгэх боломжтой болгоход зайлшгүй чухал гэж өөрийн тодорхойлсон дотоод хяналтуудын талаарх хариуцлагыг хүлээнэ.

Удирдлага компанийн санхүүгийн тайланг гаргах болон үйл ажиллагааг тасралтгүй хэвийн явуулах чадамжтай байх үүрэг хариуцлагыг хүлээнэ. Аудитын явцад тасралтгүй үйл ажиллагаатай холбоотой материаллаг тодорхой бус байдал бидэнд ажиглагдаагүй

Засаглах эрх мэдэл бүхий этгээдүүд нь компанийн санхүүгийн тайлагналын үйл явцад хяналт тавих үүрэг хариуцлагатай байна.

Санхүүгийн тайлангийн аудитад хүлээх аудиторын үүрэг хариуцлага

Залилан эсвэл алдаанаас үүссэн материаллаг буруу илэрхийлэлгүй санхүүгийн тайлан гэсэн үг үндэслэлтэй нотолгоо олж авах, дүгнэлт бүхий аудиторын тайлан гаргах нь бидний зорилго юм. Үл үндэслэлтэй нотолгоо гэдэг нь өндөр түвшний нотолгоо боловч АОУС-ын дагуу хийгдсэн аудитаар байгаа материаллаг буруу илэрхийллийг байнга илрүүлдэг гэсэн нотолгоо болохгүй. Буруу илэрхийлэх явдал нь залилан эсвэл алдаанаас үүсч болох ба хэрэв тэр нь дангаараа эсвэл нийтдээ санхүүгийн тайланд үндэслэн гаргасан хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх магадлалтай бол материаллагт тооцдог.

Энэхүү тайлан нь Монгол улсын "Компанийн тухай" хуулийн 94 дүгээр зүйлд зааснаар хувьцаа эзэмшигчийн хүсэлтийн дагуу хийгдэж аливаа өөр зорилго агуулаагүй.

ЗАХИРАЛ

М.СЭВЖИДМАА



2025 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31-НИЙ ӨДРӨӨР ТАСАЛБАР БОЛСОН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ХУРААНГҮЙ ҮЗҮҮЛЭЛТҮҮД

"Гемес центр"ХК
(Байгууллагын нэр)

СТА/2025/04

ҮЗҮҮЛЭЛТ	/төгрөг/		
	2024 оны 12 сарын 31	2025 оны 12 сарын 31	Тайлант оны/өсөл+/бууралт-/
А.ХӨРӨНГӨ			
1. Эргэлтийн хөрөнгө			
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө	3,201,237,615.59	3,452,797,715.91	251,560,100.32
Дансны авлага	-	-	-
Татвар, НДШ-ийн авлага	-	-	-
Бусад авлага	68,170,345.50	68,170,345.50	-
Бусад санхүүгийн хөрөнгө	-	-	-
Бараа материал	10,009,351.67	9,179,282.25	(830,069.42)
Урьдчилж төлсөн зардал /тооцоо	-	-	-
Бусад эргэлтийн хөрөнгө	-	-	-
Борлуулах зорилгоор эзэмшиж буй эргэлтийн бус хөрөнгө	-	-	-
Эргэлтийн хөрөнгийн дүн	3,279,417,312.76	3,530,147,343.66	250,730,030.90
2.Эргэлтийн бус хөрөнгө			
Үндсэн хөрөнгө	3,448,721,821.76	3,300,394,143.26	(148,327,678.50)
Биет бус хөрөнгө	2,288,496,000.00	2,288,496,000.00	-
Биологийн хөрөнгө	-	-	-
Урт хугацаат хөрөнгө оруулалт	-	-	-
Хайгуул ба үнэлгээний хөрөнгө	-	-	-
Хойшлогдсон татварын хөрөнгө	-	-	-
Хөрөнгө оруулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгө	-	-	-
Бусад эргэлтийн бус хөрөнгө	-	-	-
Дуусаагүй барилга	-	-	-
Эргэлтийн бус хөрөнгийн дүн	5,737,217,821.76	5,588,890,143.26	(148,327,678.50)
НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	9,016,635,134.52	9,119,037,486.92	102,402,352.40
ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ			
3. Богино хугацаат өр төлбөр			
Дансны өглөг	-	-	-
Цалингийн өглөг	-	-	-
Татварын өр	97,038,511.71	110,694,328.59	13,655,816.88
НДШ-ийн өглөг	-	-	-
Богино хугацаат зээл	-	-	-
Хүүний өглөг	-	-	-
Ногдол ашгийн өглөг	-	-	-
Урьдчилж орсон орлого	12,826,339.22	14,234,841.73	1,408,502.51
Нөөц /өр төлбөр/	-	-	-
Бусад богино хугацаат өр төлбөр	289,090,556.14	299,425,799.58	10,335,243.44
Борлуулах зорилгоор эзэмшиж буй эргэлтийн бус хөрөнгө (борлуулах бүлэг хөрөнгө)-нд хамаарах өр төлбөр	-	-	-
Богино хугацаат өр төлбөрийн дүн	398,955,407.07	424,354,969.90	25,399,562.83
4. Урт хугацаат өр төлбөр			
Урт хугацаат зээл	-	-	-
Нөөц /өр төлбөр/	-	-	-
Хойшлогдсон татварын өр	-	-	-
Бусад урт хугацаат өр төлбөр	-	-	-
Урт хугацаат өр төлбөрийн дүн	-	-	-
Өр төлбөрийн нийт дүн	398,955,407.07	424,354,969.90	25,399,562.83
5. Эзэмшигчийн өмч			

Өмч:	- төрийн	-	-
	- хувийн	-	-
	- хувьцаат	7,854,300,100.00	7,854,300,100.00
Халаасны хувьцаа	-	-	-
Нэмж төлөгдсөн капитал	-	-	-
Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	-	-	-
Гадаад валютын хөрвүүлэлтийн нөөц	-	-	-
Эздийн өмчийн бусад хэсэг	-	-	-
Хуримтлагдсан ашиг	763,379,627.45	840,382,417.02	77,002,789.57
Эздийн өмчийн дүн	8,617,679,727.45	8,694,682,517.02	77,002,789.57
ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН	9,016,635,134.52	9,119,037,486.92	102,402,352.40

ОРЛОГЫН ДЭЛГЭРЭНГҮЙ ТАЙЛАН

Цэвэр борлуулалт	2,577,488,789.61	3,096,218,125.04	518,729,335.43
Борлуулалтын өртөг	-	-	-
Нийт ашиг (алдагдал)	2,577,488,789.61	3,096,218,125.04	518,729,335.43
Түрээсийн орлого	-	-	-
Хүүний орлого	450,787,218.18	523,009,996.47	72,222,778.29
Ногдол ашгийн орлого	-	-	-
Эрхийн шимтгэлийн орлого	-	-	-
Бусад орлого	-	-	-
Борлуулалт, маркетингийн зардал	-	-	-
Ерөнхий ба удирдлагын зардал	1,055,868,332.77	1,315,334,469.35	259,466,136.58
Санхүүгийн зардал	-	-	-
Бусад зардал	-	-	-
Гадаад валютын ханшийн зөрүүний олз(гарз)	232.43	3,243.76	3,011.33
Үндсэн хөрөнгө данснаас хассаны олз (гарз)	-	-	-
Биет бус хөрөнгө данснаас хассаны олз(гарз)	-	-	-
Хөрөнгө оруулалт борлуулсанаас үүссэн олз (гарз)	-	-	-
Бусад ашиг (алдагдал)	-	-	-
Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)	1,972,407,907.45	2,303,896,895.92	331,488,988.47
Орлогын албан татварын зардал	197,240,767.50	230,389,365.20	33,148,597.70
Ердийн үйл ажиллагааны татварын дараах ашиг (алдагдал)	1,775,167,139.95	2,073,507,530.72	298,340,390.77
Зогсоосон үйл ажиллагааны татварын дараах ашиг (алдагдал)	-	-	-
Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	1,775,167,139.95	2,073,507,530.72	298,340,390.77
Бусад дэлгэрэнгүй орлого	-	-	-
Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэлийн	-	-	-
Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	-	-	-
Бусад олз (гарз)	-	-	-
Орлогын нийт дүн	1,775,167,139.95	2,073,507,530.72	298,340,390.77
Нэгж хувьцаанд ногдох суурь ашиг	-	-	-

ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН

Өмч	7,854,300,100.00	7,854,300,100.00	-
Халаасны хувьцаа	-	-	-
Нэмж төлөгдсөн капитал	-	-	-
Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	-	-	-
Гадаад валют хөрвүүлэлтийн нөөц	-	-	-
Эзэмшигчийн өмчийн бусад хэсэг	-	-	-
Хуримтлагдсан ашиг /- алдагдал/	763,379,627.45	840,382,417.02	77,002,789.57
Нийт дүн	8,617,679,727.45	8,694,682,517.02	77,002,789.57


МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН

1. ҮНДСЭН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ			
Мөнгөн орлогын дүн (+)	2,866,397,017.54	3,517,203,307.89	650,806,290.35

Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого	2,804,402,946.62	3,351,136,643.17	546,733,696.55
Эрхийн шимтгэл, хураамж, төлбөрийн орлого	-	-	-
Даатгалын нөхвөрөөс хүлээн авсан мөнгө	-	-	-
Буцаан авсан албан татвар	-	-	-
Татаас, санхүүжилтийн орлого	-	-	-
Бусад мөнгөн орлого	61,994,070.92	166,066,664.72	104,072,593.80
Мөнгөн зарлагын дүн (-)	1,489,259,485.73	1,906,053,934.13	416,794,448.40
Ажиллагчдад төлсөн	419,857,899.00	526,096,764.00	106,238,865.00
Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	91,683,907.00	113,559,390.00	21,875,483.00
Бараа материал худалдан авахад төлсөн	41,494,105.00	18,621,730.00	(22,872,375.00)
Ашиглалтын зардалд төлсөн	165,539,746.77	205,984,428.47	40,444,681.70
Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн	2,003,750.00	702,200.00	(1,301,550.00)
Хүүний төлбөрт төлсөн	-	-	-
Татварын байгууллагад төлсөн	634,939,895.52	723,106,650.14	88,166,754.62
Даатгалын төлбөрт төлсөн	-	-	-
Бусад мөнгөн зарлага	133,740,182.44	317,982,771.52	184,242,589.08
Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	1,377,137,531.81	1,611,149,373.76	234,011,841.95
2. ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ			-
Мөнгөн орлогын дүн (+)	450,787,218.18	523,009,996.47	72,222,778.29
Үндсэн хөрөнгө борлуулсны орлого	-	-	-
Биет бус хөрөнгө борлуулсны орлого	-	-	-
Хөрөнгө оруулалт борлуулсны орлого	-	-	-
Бусад урт хугацаат хөрөнгө борлуулсны орлого	-	-	-
Бусдад олгосон зээл, мөнгөн урьдчилгааны буцаан төлөлт	-	-	-
Хүлээн авсан хүүний орлого	450,787,218.18	523,009,996.47	72,222,778.29
Хүлээн авсан ногдол ашиг	-	-	-
Мөнгөн зарлагын дүн (-)	2,715,900.00	13,439,400.00	10,723,500.00
Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	2,715,900.00	13,439,400.00	10,723,500.00
Биет бус хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	-	-	-
Хөрөнгө оруулалт олж эзэмшихэд төлсөн	-	-	-
Бусад урт хугацаат хөрөнгө олж эзэмшихэд	-	-	-
Бусдад олгосон зээл болон урьдчилгаа	-	-	-
Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	448,071,318.18	509,570,596.47	61,499,278.29
3. САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ			-
Мөнгөн орлогын дүн (+)	-	-	-
Зээл авсан, өрийн үнэт цаас гаргаснаас хвлээн авсан	-	-	-
Хувьцаа болон өмчийн бусад үнэт цаас гаргаснаас хүлээн авсан	-	-	-
Төрөл бүрийн хандив	-	-	-
Бусад	-	-	-
Мөнгөн зарлагын дүн (-)	1,602,973,666.80	1,869,163,113.68	266,189,446.88
Зээл, өрийн үнэт цаасны төлбөрт төлсөн	-	-	-
Санхүүгийн түрээсийн өглөгт төлсөн	-	-	-
Хувьцаа буцаан худалдаж авахад төлсөн	-	-	-
Төлсөн ногдол ашиг	1,602,973,666.80	1,869,163,113.68	266,189,446.88
Бусад	-	-	-
Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	(1,602,973,666.80)	(1,869,163,113.68)	(266,189,446.88)
Валютын ханшийн зөрүү	232.42	3,243.77	3,011.35
Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	222,235,415.61	251,560,100.32	29,321,673.36
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний	2,979,002,199.98	3,201,237,615.59	222,235,415.61
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн	3,201,237,615.59	3,452,797,715.91	251,560,100.32

АУДИТОР


Д.ЧУЛУУНБАТ



КОМПАНИЙН ЗАСАГЛАЛЫН БҮТЭЦ

“Гермес Центр” ХК-ийн засаглалын тогтолцоо нь хувьцаа эзэмшигчид, компанийн нийт ажилтан ажиллагсад, түрээслэгч, үйлчлүүлэгч зэрэг талуудын ашиг сонирхлын тэнцвэрийг хангаж, компанийн зорилго, зорилт, үйл ажиллагааны үндсэн чиглэлийг тодорхойлох, чиглүүлэх, хянахад чиглэсэн бүтэц юм.

График 3



ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРАЛ

“Гермес Центр” ХК нь “Компанийн тухай хууль”, “Компанийн дүрэм”, “Хувьцаат компанийн хувьцаа эзэмшигчдийн хурлын зар хүргэх журам”-ын дагуу 2024 оны хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг амжилттай зохион байгууллаа.

Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд хурлын материалтай урьдчилан танилцаж саналаа өгсөн 42,530,145 саналын эрхтэй 1 хувьцаа эзэмшигч, хуралд биечлэн оролцож саналаа өгсөн 23,725,299 саналын эрхтэй 17 хувьцаа эзэмшигчид хүрэлцэн ирсэн бөгөөд хурлын ирц 84.37%-тай байсан.

Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд ТУЗ-ийн дарга Д.Оюунсүрэн ТУЗ-ийн дэргэдэх Эрсдэл аудитын хорооны дарга, ТУЗ-ийн хараат бус гишүүн Д.Туяа, хараат бус гишүүн Б.Алтангэрэл, ердийн гишүүн Б.Оюунцэцэг, Б.Амарсанаа, Ц.Түвшинжаргал, Д.Алтанчимэг нар биечлэн

оролцлоо. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар дараах асуудлуудыг хэлэлцэн баталсан. Үүнд:

1. Компанийн 2024 оны үйл ажиллагааны болон санхүүгийн аудитлагдсан тайланд ТУЗ-өөс гаргасан дүгнэлтийг хуралд оролцсон хувьцаа эзэмшигчдийн 100%-ийн саналаар батлав.
2. Компанийн ТУЗ-ийн 2025 оны төсвийг хуралд оролцсон хувьцаа эзэмшигчдийн 100%-ийн саналаар батлав.

Хувьцаа эзэмшигчдийн хурлаар хэлэлцэн баталсан тогтоол шийдвэр, хурлын материалыг холбогдох хууль тогтоомж, журмын дагуу Санхүүгийн зохицуулах хороо болон Монголын хөрөнгийн биржид хүргүүлсэн. Мөн хурлын мэдээллийг Монголын хөрөнгийн биржийн сайтанд байршуулсан болно.

КОМПАНИЙН ЗАСАГЛАЛЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА

“Гермес Центр” ХК нь Монгол Улсын хууль, холбогдох хууль тогтоомжууд болон Санхүүгийн зохицуулах хороо, Монголын хөрөнгийн биржээс тус тус баталсан дүрэм, журмыг үйл ажиллагаандаа мөрдөж ажилладаг.

1. Компанийн ТУЗ-ийн ээлжит хурлуудыг (2025.02.14, 2025.05.29, 2025.08.28) холбогдох хууль журмын дагуу зохион байгуулж, хурлаас гаргасан тогтоол шийдвэрүүдийг СЗХ болон МХБиржид хүргүүлсэн.
2. Компанийн хувьцаа эзэмшигчдийн 2024 оны ээлжит хурлыг 2025 оны 4-р сарын 4-ний өдөр зохион байгуулсан бөгөөд хурлаас гаргасан тогтоол шийдвэрүүдийг холбогдох материалуудын хамт СЗХороо, МХБиржид тус тус хүргүүлсэн.
3. Компанийн ТУЗ-ийн шийдвэрийн дагуу 2024 оны сүүлийн хагас жил, 2025 оны эхний хагас жилийн ногдол ашгийн мөнгийг компанийн төв байр болон “Үнэт цаас төвлөрсөн хадгаламжийн төв”-тэй гэрээ байгуулан хувьцаа эзэмшигчдийн дансанд бүрэн байршуулан тараалаа.
4. СЗХорооноос баталсан “Үнэт цаасны бүртгэлийн журам”-ын дагуу компанийн тухай бүр мэдээлэх мэдээллүүдийг МХБ-ийн www.mse.mn цахим хуудас, өөрийн компанийн www.hermescenter.mn цахим хуудсанд тус тус нийтэлж олон нийтэд мэдээллээ.
5. СЗХ болон МХБиржээс баталсан заавар журмуудыг өдөр тутамдаа хэрэгжүүлэн ажиллаж байна.
6. Компанийн вэб сайт, мэдээллийн самбарны мэдээ мэдээллийг тогтмол шинэчилж, хөрөнгө оруулагч, хувьцаа эзэмшигчид, түрээслэгчдэд мэдээлэл авах боломжийг бүрдүүлэн ажиллаж ирлээ.
7. Компанийн 2024 оны эхний хагас жилийн ногдол ашиг авах эрхтэй хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалт гаргасан бүртгэлийн өдрөөр тасалбар болгосон хувьцаа эзэмшигчдийн дунд хийсэн судалгааг ТУЗ-ийн хуралд танилцуулж ажилласан.
8. Бүртгэлтэй брокер дилерийн компаниудаас ирүүлсэн хүсэлтийн дагуу компанийн гадаад дотоодын хувьцаа эзэмшигчдийг гүйцэтгэх захирал хүлээн авч холбогдох мэдээ, мэдээллийг өгч ажилласан.

КОМПАНИЙН ЗАСАГЛАЛЫН КОДЕКСИЙН ХЭРЭГЖИЛТ

Монголын хөрөнгийн биржийн “Компанийн засаглалын кодексийг үнэлэх үнэлгээ”-ний аргачлалын дагуу 2025 оны 12-р сарын 30-ны өдрийн байдлаарх “Термес Центр” ХК-ийн засаглалын кодексийн хэрэгжилтийн үнэлгээний тайлан

Хүснэгт 1

№	Гарчиг	Авбал зохих нийт оноо	2025. 12. 30-ны өдрийн байдлаар өөрийн	
			Үнэлсэн	Хувь
1	ТУЗ-ийн бүтэц, зохион байгуулалт	12	12	100%
2	ТУЗ-ийн дэргэдэх хороод, тэдгээрийн чиг үүрэг	10	10	100%
3	Тайлагнал, мэдээллийн ил тод, байдал	6	6	100%
4	Аудит, хяналтын тогтолцоо	6	6	100%
5	Эрсдэлийн удирдлага	8	8	100%
6	Эрх бүхий албан тушаалтны цалин урамшуулал	6	6	100%
7	Оролцогч талуудын эрх ашиг	8	8	100%
8	Компанийн соёл	6	6	100%
9	Хувьцаа эзэмшигчдийн эрх	10	10	100%
Нэгдсэн дүн		72	72	100%

КОМПАНИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧИД

Манай компани нь 2025 оны 9-р сарын 15-ны өдрөөр нийт 1091 хувьцаа эзэмшигчидтэй байсан бөгөөд дараах бүтэц, бүрэлдэхүүнтэй байна. Үүнд:

Компанийн хувьцаа эзэмшигчдийн бүтэц

Хүснэгт 2

№	Хувьцаа эзэмшигчдийн бүтэц	Хувьцаа эзэмшигчдийн иргэншил	Хувьцаа эзэмшигчдийн тоо	Эзэмшиж буй хувьцааны	
				Тоо ширхэг	Нийт хувьцаанд эзлэх хувь
1	Байгууллага	Гадаад	3	4,874,255	6.2%
2		Дотоод	19	328,818	0.42%
3	Иргэн	Гадаад	24	2,112,274	2.68%
4		Дотоод	1045	71,227,654	90.7%
Нийт			1091	78,543,001	100%

Компанийн нөлөө бүхий хувьцаа эзэмшигчид

Хүснэгт 3

№	Хувьцаа эзэмшигчийн нэр	Эзэмшиж буй хувьцааны тоо ширхэг	Нийт хувьцаанд эзлэх хувь
1	Иргэн Д.Зоригт	42,530,145	54.15%
2	Иргэн Д.Оюунсүрэн	23,460,015	29.87%
3	"Импера монголиа холдинг" ХХК	4,805,817	6.12%
4	Бусад	7,747,024	9.86%
Нийт хувьцааны тоо		78,543,001	100%

КОМПАНИЙН НЭГДМЭЛ СОНИРХОЛТОЙ ЭТГЭЭДИЙН ТАЛААР

Компанийн нэгдмэл сонирхолтой этгээд, тэдгээрийн эзэмшиж буй хувьцааны тоо ширхэг, эзэмшлийн хувь хэмжээний талаарх мэдээлэл. Компанийн нийт хувьцааны тоо : 78,543,001

Хүснэгт 4

№	Нэгдмэл сонирхолтой этгээдийн овог нэр	Эрхэлж буй ажил,	Эзэмшиж буй хувьцааны	
			Тоо ширхэг	Эзэмшлийн хувь
1	Дашзэвэг овогтой Зоригт	Иргэн	42,530,145	54.15
2	Дугаржав овогтой Оюунсүрэн	“Улаанбаатар дахь Америк ерөнхий боловсролын сургууль” ХХК-ийн гүйцэтгэх захирал	23,460,015	29.87
Нийт			65,990,160	84.02

КОМПАНИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН БҮРЭЛДЭХҮҮН

Манай компанийн ТУЗ нь хувьцаа эзэмшигчдийн хурлын чөлөөт цагт компанийн эрх барих дээд байгууллага байдаг. ТУЗ-ийн 9 гишүүдийг компанийн 2021 оны 4-р сарын 9-ний өдрийн хувьцаа эзэмшигчдийн хурлаас “Компанийн дүрэм”-ийн 7.23-р заалтын дагуу 5 жилийн хугацаатай улируулан сонгосон байна.

“Компанийн засаглалын кодекс”-т нийцүүлэн ТУЗ-ийн дэргэдэх хороодын дарга, гишүүдийн 2/3-ыг хараат бус гишүүдээр томилох асуудлыг хэлэлцэж, улмаар хороодын бүтэц бүрэлдэхүүнийг шинэчлэн томилсон.

Хүснэгт 5

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ДЭРГЭДЭХ ХОРООДЫН БҮРЭЛДЭХҮҮН

Эрсдэл аудитын хорооны бүрэлдэхүүн

Дарга	Д.Туяа	ТУЗ-ийн хараат бус гишүүн
Гишүүн	Н.Батсайхан	ТУЗ-ийн хараат бус гишүүн
Гишүүн	Н.Мөнхзул	ТУЗ-ийн ердийн гишүүн

Цалин урамшууллын хорооны бүрэлдэхүүн

Дарга	Б.Алтангэрэл	ТУЗ-ийн хараат бус гишүүн
Гишүүн	Д.Оюунсүрэн	ТУЗ-ийн ердийн гишүүн
Гишүүн	Д.Туяа	ТУЗ-ийн хараат бус гишүүн

Нэр дэвшүүлэх хорооны бүрэлдэхүүн

Дарга	Н.Батсайхан	ТУЗ-ийн хараат бус гишүүн
Гишүүн	Б.Алтангэрэл	ТУЗ-ийн хараат бус гишүүн
Гишүүн	Б.Оюунцэцэг	ТУЗ-ийн ердийн гишүүн

КОМПАНИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛ БОЛОН ТУЗ-ИЙН ДЭРГЭДЭХ ХОРООДЫН ТАЙЛАН


